



ТЭЭВЭР ХӨГЖЛИЙН БАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХАРААТ БУС ГИШҮҮН Б.ОЮУНЦАЦРАЛЫН
2024 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН
АЖЛЫН ТАЙЛАН

2024 оны 10 сарын 15
Улаанбаатар хот

Тээвэр хөгжлийн банкны Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор Б.Оюунцацрал миний бие 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн тус банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний хувьд Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа “Компанийн тухай хууль, Банкны тухай хууль” болон Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан “Банкны Зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”, “Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”, Тээвэр хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам, Банкны Дүрэм болон бусад холбогдох хууль тогтоомжийг тус тус мөрдөж хэрэгжүүлэн ажилласан болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оролцсон байдал

Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 09 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд нийт 5 удаа хуралдсан бөгөөд дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэхэд саналын эрхтэй оролцсон болно. Үүнд:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн №Т/24-11 дугаартай хурлаар

- Тээвэр хөгжлийн банкны 2024 оны 6 дугаар сарын байдлаарх банкны санхүүгийн гүйцэтгэлийн тайлангаар танилцсан;
- банкны 2024 оны эхний хагас жилийн байдлаарх их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх тайлангаар танилцсан;
- банкны тогтвортой санхүүжилтийн бодлогын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулан баталсан;
- эрсдэлийн аппетитийн мэдэгдэлд нэмэлт өөрчлөлт оруулан баталсан;
- банкны бүтэц, орон тоонд нэмэлт өөрчлөлт оруулан баталсан;
- эрсдэлийн нэгдсэн тайлангаар танилцсан;
- банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Т.Баасанжавын зөвшөөрөл Монголбанкаас ирсэнтэй холбоотойгоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулахаар тус тус шийдвэрлэсэн бөгөөд дээрх асуудлуудыг хэлэлцэхэд саналын зөрүүтэй байр суурь байгаагүй болно.

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн №Т/24-12 дугаартай хурлаар

- банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулан батлахаар шийдвэрлэсэн;
- Дотоод аудитын газрын ахлах аудиторыг өөрийн гаргасан хүсэлтийн дагуу үүрэгт ажлаас чөлөөлөхөөр шийдвэрлэсэн;
- банкны төсвийн тодотгол болох үйл ажиллагааны зардал, хөрөнгө оруулалтын зардлын төсвийг тус тус хавсралтаар батлахаар шийдвэрлэсэн;
- санхүүгийн тайлангийн хөндлөнгийн аудитын байгууллагаар олон улсын "BDO"-ийг сонгон аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулах эрхийг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Сандагсүрэнд олгосон;
- банкны өмчлөлийн "5038 УАР" улсын дугаартай "TESLA X" маркийн тээврийн хэрэгслийг, "2320 УАР" дугаартай "Toyota alphard" маркийн тээврийн хэрэгслийг тус тус худалдах, "Changan SC6471EAA6HEV" маркийн бензин цахилгаан хосолсон тээврийн хэрэгслийг банкны өмчлөлд худалдан авах саналыг зөвшөөрсөн;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын гаргасан хүсэлтийн талаар хэлэлцүүлэх, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай асуудлуудыг тус тус хэлэлцүүлэхээр хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулахаар шийдвэрлэв.

Миний зүгээс хурлын дээрх шийдвэрүүдийг дэмжсэн бөгөөд, зөрүүтэй байр суурь байгаагүй болно.

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн №Т/24-13 дугаартай хурлаар

- Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг томилох тухай асуудлыг хэлэлцэн С.Цэрэндашийг төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар томилохоор шийдвэрлэсэн;
- банкны Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч томилж, Гүйцэтгэх захирлыг нэр дэвшүүлэх тухай асуудлыг хэлэлцэн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Батчулуун овогтой Эрдэнэбаярыг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчээр 2024 оны 8 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн томилж, Гүйцэтгэх захиралд нэр дэвшүүлэн түүний холбогдох баримт бичгийг зохих журмын дагуу зөвшөөрөл

авахаар Монголбанканд хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад үүрэг болгосон;

- Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч томилогдсонтой холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулан батлахаар шийдвэрлэсэн.

4. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн №Т/24-14 дугаартай хурлаар

- Дотоод аудитын газрын Мэдээллийн технологийн аудитын хэлтсийн ахлах аудиторыг өөрийн гаргасан хүсэлтийн дагуу үүрэгт ажлаас чөлөөлөх тухай асуудлыг хэлэлцэн түүнийг 2024 оны 9 дүгээр сарын 10-ны өдрөөр дуусгавар болгон үүрэгт ажлаас чөлөөлөхөөр шийдвэрлэсэн;
- Дотоод аудитын газрын Ерөнхий аудитын хэлтсийн аудитор албан тушаалд туршилтын 3 сарын хугацаатайгаар Б.Ганцолмонг 2024 оны 9 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн, Б.Батцэцгийг 2024 оны 9 дүгээр сарын 09-ний өдрөөс эхлэн тус тус томилохоор шийдвэрлэсэн;
- зээлдэгч Батчулуун овогтой Эрдэнэбаярт ажилтны орон сууцны зээл болох 600,000,000 /зургаан зуун сая/ төгрөгийг жилийн 6 хувийн хүүтэй, 2 жил буюу 24 сарын хугацаатайгаар олгохыг зөвшөөрч, зээл олгох үйл ажиллагааг хууль, журамд нийцүүлэн гүйцэтгэх ажиллах, зээлийн гэрээ болон барьцааны гэрээнд гарын үсэг зурах эрхийг банкны зээл хариуцсан захирал /М.Батмөнх/-д үүрэг болгосон.

Дээрх асуудлуудад миний бие хараат бус гишүүний хувьд холбогдох дүгнэлтийг гарган ажилласан.

**Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх
Аудитын хорооны хуралд оролцсон байдал**

Миний бие Аудитын хорооны хурлыг тус хорооны даргын хувьд удирдан явуулсан. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны 2024 оны 07 дугаар сарын 19-нд хуралдсан бөгөөд тус хурлаар нийт 5 асуудлыг хэлэлцэж, санал дүгнэлт гарган Гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч ажилласан бөгөөд тус хурлаар дараахь асуудлуудыг хэлэлцсэн. Үүнд:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны хурлаас өгсөн үүргийн хэрэгжилтийг танилцуулах тухай, Дотоод аудитын газрын 2024 оны эхний хагас жилийн ажлын гүйцэтгэлийн тайлан танилцуулах тухай
2. Шангри-ла салбарт хийсэн аудитын тайлан танилцуулах тухай
3. Сэнтрал салбарт хийсэн аудитын тайлан танилцуулах тухай
4. Мэдээллийн аюулгүй байдлын хэлтэст хийсэн аудитын тайлан танилцуулах тухай
5. Банкны их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх тайлан танилцуулах тухай /2024 оны эхний хагас жил/

Дээрх асуудлуудыг хэлэлцэж дараахь санал дүгнэлтийг гарган гүйцэтгэх удирдлагад үүрэг болгож ажилласан. Үүнд:

1. Дотоод аудитын газраас өгсөн хугацаатай болон хугацаагүй зөвлөмжүүдийг цаг тухай бүрт нь хэрэгжүүлж ажиллахад анхаарах.
2. Хүний нөөцийн газар болон Салбарын удирдлагын газар нь банкны хэмжээнд салбаруудад авч буй шинэ ажилтнуудыг сонгон шалгаруулах ажилд анхаарч, хүний нөөцийн бодлогыг баримталж ажиллахад анхаарах, тухайн ажил мэргэжилд тохирох мэргэжлийн ур чадвартай хүнийг ажилд авах, цаашид банканд тогтвор суурьшилтай ажиллахад нь анхаарахыг Хүний нөөцийн газар, Салбарын удирдлагын газар болон Гүйцэтгэх захиралд тус тус үүрэг болгосон.
3. Салбарын удирдлага болон салбарын ажилтнууд банкны дотоод журам зааврыг баримталж ажиллахад хатуу анхаарах, мөн харилцагчийн бүртгэлийн асуудал дээр Харилцагчийн бүртгэлийн газартай хамтарч хяналт тавьж ажиллах.
4. Банканл мөрдөгдөж буй бодлого, дүрэм, журам зааврыг мөрдөж ажиллан, мөрдөж ажиллаагүй, зөрчил гаргасан ажилтнуудад хариуцлага тооцож байхыг Салбарын удирдлагын газар, Хүний нөөцийн газар болон Хууль эрх зүйн газарт үүрэг болгосон.
5. Харилцагчийн бүртгэл, хувийн хэргийн болон баримт бичгийн бүрдэлтэд анхаарч, цаг тухай бүрт харилцагчийн хувийн хэргийн бүртгэлийг анхаарч ажиллахыг харилцагчийн бүртгэлийн газарт үүрэг болгосон.
6. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Б.Мөнхбаяр нь байгууллагуудад мэдээлэл технологийн чиглэлээр нарийн мэргэжлийн консалтинг үйлчилгээ үзүүлж, IT-н үүрэг функцуудыг хариуцан ажилладаг байгууллагатай бөгөөд Тээвэр Хөгжлийн Банкны Мэдээллийн технологийн газартай хамтран Мэдээллийн технологийн газар болон Мэдээллийн аюулгүй байдлын хэлтэст орхигдоод байгаа ажлуудын жагсаалт гарган, тэрхүү ажлуудыг аутсорсинг-р хийлгэж

шийдвэрлэх эсэх дээр хамтарч ажиллахад бэлэн байгаа тул тус асуудлаар хандаж зөвлөгөө, мэдээлэл авч ажиллахыг Гүйцэтгэх захирал, Мэдээллийн технологийн газар болон Мэдээллийн аюулгүй байдлын хэлтэст санал болгов..

7. Зохих журмын дагуу Мэдээллийн технологийн газар болон Мэдээллийн аюулгүй байдлын хэлтэс хоорондын чиг үүргийн хувьд тодорхой болгохыг Гүйцэтгэх удирдлагын дэргэдэх Удирдлагын хороонд үүрэг болгож, Дотоод аудитын газар болон ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны хурлын дараагийн хуралд хэрэгжилтийг тайлагнахыг тус тус үүрэг болгов.

**Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн
удирдлагын хорооны хуралд оролцсон байдал**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны 2024 оны 7 дугаар сарын 19-нд хуралдсан бөгөөд тус хурлаар нийт 3 асуудал болох 2024 оны эхний хагас жилийн байдлаарх эрсдэлийн нэгдсэн тайлан, эрсдэлийн аппетитийн мэдэгдлийн хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай санал мөн тусгай активын нэгжийн тайлангийн талаар тус тус хэлэлцэн дараах санал дүгнэлтийг гаргасан. Үүнд:
 - Нийт чанаргүй зээл нь нийт зээлийн багцын 9.5 хувиас хэтрэхгүй байхаар хангаж ажиллах.
 - Зээлийн өр төлбөрт тооцож зээлдэгчээс банкны өмчлөлд шилжүүлэн авах хөрөнгийг нийт зээлийн багцын 5 хувиас хэтрэхгүй хэмжээнд хангаж ажиллах.
 - Зээлдэгчийн хүсэлтээр хүү, нэмэгдүүлсэн хүүгийн төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх тохиолдолд нийт хөнгөлөх, чөлөөлөх дүн нь банкны тухайн жилийн нийт хүүгийн орлогын 1 хувиас хэтрэхгүй хэмжээнд барьж ажиллах.
 - Нийт чанаргүй зээл <9.5% байх.
 - Өмчлөх бусад хөрөнгө/нийт зээлийн багц <5% байх.
 - Зээлийн хүү чөлөөлөх хэмжээ/тухайн жилийн орлого <1% байх.
 - Тусгай активын нэгжийн тайлантай танилцаж, тус нэгжийн ажилтнуудад зохих журмын дагуу урамшуулал олгодог болох зохицуулалтыг хийх ажлыг зохион байгуулж ажиллахыг гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосон.

**Сонирхлын зөрчилтэй хэлцэл ба их
хэмжээний хэлцлийн тайлан**

Монгол Улсын Банкны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэгт Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн нь сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлахад заавал оролцож, санал өгнө гэж заасан.

Тайлант хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн №Т/24-14 дугаартай хурлаар хэлэлцсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах асуудалд миний бие оролцож, саналаа өгсөн болно.

Хувьцаа эзэмшигч, Төлөөлөн удирдах зөвлөл ба Гүйцэтгэх удирдлагын багийн хоорондох мэдээлэх процесс, ил тод байдал, шийдвэр гаргалт нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон холбогдох Монголбанкны дүрэм журмын дагуу явагдажбайгаа болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн
хараат бус гишүүн Б.Оюунцацрал

